

ГЛОБАЛЬ САНГИЙН ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ, СҮРЬЕЭГИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЭГИЙН ГИШҮҮД ТӨВ, ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ АЙМГУУДАД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦСАН АЖЛЫН ТАЙЛАН

Хугацаа: 2019 оны 4 дүгээр сарын 8-наас 11-ний өдрүүд

Хамрагдсан газрууд:

Төв аймаг

- Эрүүл Мэндийн Газар
- Нэгдсэн Эмнэлэг

Дундговь аймаг

- Эрүүл Мэндийн Газар
- Нэгдсэн Эмнэлэг
- МӨАУМХолбоо

Өмнөговь аймаг

- Эрүүл Мэндийн Газар
- Бүсийн Оношлогоо Эмчилгээний Төв
- МӨАУМХолбоо

Ажилласан бүрэлдэхүүн:

1. Ц.Адьяахишиг, ҮЗЭ-ийн төрийн байгууллагын төлөөлөл
2. Ц.Даваасүрэн, Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нэгдсэн Холбоо
3. Г.Нямпүрэв, ҮЗЭ-ийн эрсдэлт бүлгийн хүн амын төлөөлөл
4. Б.Баярмаа, ҮЗЭ-ийн эрсдэлт бүлгийн хүн амын төлөөлөл
5. Р.Асай, ЭМЯ-ны дүрс оношлогоо судлалын зөвлөлийн гишүүн
6. Д.Мөнхбаатар, ЭМЯ-ны дүрс оношлогоо судлалын зөвлөлийн гишүүн
АШИУҮС-ийн радиологийн тэнхимийн ахлах багш
7. Ж.Лхамсүрэн, ХЗН-ийн Ханган нийлүүлэлт хариуцсан мэргэжилтэн
8. Б.Гансүх, ХЗН-ийн ДОХ, сүрьеэгийн төслийн мэргэжилтэн
9. Н.Ганболд, ХӨСҮТ-ийн БЗДХ-ын кабинетын дарга
10. Д. Отгонцэцэг, ХӨСҮТ-ийн СТСА-ны их эмч
11. Б.Оюундарь, ҮЗЭ-ийн ажлын албаны зохицуулагч
12. Л.Номин-Эрдэнэ, ҮЗЭ-ийн ажлын албаны ажилтан

Зорилго:

ҮЗЭ-ийн хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлын зорилго нь төсөл хөтөлбөр саадгүй, цаг хугацаандаа, хүрэх ёстой газраа хүрч хэрэгжиж байгаа эсэхэд дэмжлэгт хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Зорилт:

- ҮЗЗ нь Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтэнд санхүү, хүний нөөц, менежмент, гүйцэтгэлийн хяналт хийх чиг үүргийн хүрээнд хөдөө орон нутагт Сүрьеэ, ХДХВ/ДОХ, БЗДХ-ын тохиолдол, өвчлөлийн байдал, төслийн хэрэгжилттэй танилцах ажлаар Төв, Дундговь болон Өмнөговь аймгуудад очиж ажиллах.
- 2018-2020 онуудад хэрэгжиж буй Глобаль Сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн шинэ төслийн хүрээнд ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтанд хяналт тавих.

ТӨВ АЙМАГ

ТӨВ АЙМГИЙН ЭМГ-ЫН УДИРДЛАГА

Уулзсан хүмүүс:

1. Ж.Алтанцэцэг, Халдварт, ЗООНОЗ ТСА-ын дарга,
2. С.Оюунцэцэг, Нэгдсэн эмнэлгийн дарга

Ерөнхий мэдээлэл:

Төв аймаг Монгол улсын дорнод төв хэсэгт 74,042.37 км² газар эзлэн оршдог. Дундаа Улаанбаатар нийслэлийг хүрээлж, бусад талаараа Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ зургаан аймагтай хиллэдэг.

Төв аймаг 95000 орчим хүн амтай бөгөөд аймаг нь 27 сум, 97 багтай.

Эрүүл мэнд:

Сүрьеэгийн өвчлөл хамгийн өндөртэй 8 аймгийн нэг. Явуулын, хөдөлгөөнт хүн ам ихтэй тул өвчлөл өндөртэй байдаг. Глобаль сангийн санхүүжилтээр 1, аймгийн санхүүжилтээр 1 хүн сүрьеэгийн резидентэд суралцаж байна. ХДХВ-ийн халдвар аймгийн хэмжээнд 4 бүртгэгдсэн бөгөөд 2019 оны 5 сард халдвартай эхийг амаржуулахаар ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хүний нөөцийн дутагдалтай. Глобаль Сангийн дэмжлэгтэй оношлуураар нийт хэрэгцээний 30%, БЗДХ-ын эмийн 90%, сүрьеэгийн эмийн 70%-ийг болон хувийн хамгаалалтын хэрэгсэл ханган нийлүүлэгдсэнийг ашиглаж байна. Түүнчлэн зөөврийн рентген аппарат, микроскоп, женексперт (4 модультай) нийт 240 сая орчим төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авсан. Дутагдсан эм, оношлуурыг тендер зарлан хүлээн авдаг. 2010 онд Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тасаг нээн ажиллуулж байна. 2010 онд ГС-ийн санхүүжилтээр Сүрьеэгийн тасагт агааржуулалтын систем суурилуулсан боловч мотор байнга эвдэрдэг. Мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг идэвхитэй зохион байгуулдаг. МСЭМХ 27 суманд сорьц тээвэрлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. МСТН 2004 оноос үйл ажиллагаа явуулж байна.

Цаашид авах арга хэмжээ:

1. 2019 онд Сүрьеэгүй аймаг нэртэй аян өрнүүлэн ажиллана.

2. МСЭМХ-той хамтран 2-р улиралд буюу 4 сарын 20-оос 5 сарын 15-ны хооронд 2 сумдаар ажиллана.
3. Цэрэг татлагын үзлэгээр 18-27 насны эрчүүдэд зөөврийн рентген аппаратаа ашиглан БЗДХ болон сүрьеэг илрүүлэхээр ажиллахаар төлөвлөж байна.
4. 9 сарын 20-ноос цэрэг татлагаар дахин үзлэг, оношлогоо хийгдэнэ. Аймгийн цэргийн штабад үзлэг оношлогооны мэдээллийг хүргүүлсэн.



БЗДХ-ЫН КАБИНЕТ, СДЗШ-НИЙ ТӨВ

Уулзсан хүмүүс:

1. А.Долгоржав, Нэгдсэн Эмнэлгийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн эмч
2. Б.Нямсанаа, БЗДХ-ын бага эмч, сувилагч эх баригч

ГС-ийн дэмжлэгээр 2017 онд аймгийн хэмжээнд 7800 хүнийг БЗДХ-ын үзлэг шинжилгээнд хамруулсанаас 223 тэмбүүгийн тохиолдол илэрсэн. Ажиллах хүч бага тул СДЗШ болон БЗДХ-ын кабинет нэг дор үйл ажиллагаагаа явуулж байгаа. Няан судлалын эмч ажилладаггүй. МСҮТ, ЕБС-иас өвчлөл ихээр илэрдэг.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Бэлгэвч, эм урвалжийн ханган нийлүүлэлт урд жилүүдийнхээс буурсан. Оношлуурын 30%, ХДХВ-ын эмийг 100% ГС-аас ханган нийлүүлдэг. Боломж бололцоондоо тулгуурлан өвчтөнгүүддээ хүргээд байхгүй эмийг жороор авахыг санал болгодог. Дутагдалтай оношлуурыг “Монос”-оос тендер зарлан хүлээн авсан.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Зорилтод хүрч байгаа. Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн өвчлөл, сайдын тушаал зэргийг үндэслэн эмийн захиалгыг хийдэг. ХӨСҮТ-ээс дунджаар 3-6 сарын эмийн нөөцийг хүлээн авдаг. Аймгийн эмийн сангаасаа захиалгын хуудсыг бөглөн эмийг хүлээн авдаг. БЗДХ-ын резидентурт хүн сургаагүй.

ХДХВ-ийн халдвартай 1 эх 2019 оны 5 сард төрнө. Халдвартай хүмүүсийн мэдээллийг кодоор оруулдаг.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: 2018 оны байдлаар 129 тэмбүү, 74 заг хүйтэн, 79 трихомониаз илэрсэн нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

ТАЙЛАН: Төслийн тайланг улирал бүр ХӨСҮТ-рүү илгээдэг.



ҮЗЭ-ийн ЗӨВЛӨМЖ:

- Түргэвчилсэн оношлуурыг авч хэрэглэн СДЗШ-ний төвийн үйл ажиллагааг тогтмол явуулах. Өмнө нь байсан төвийн байршлаас дордуулсан байгаа тул цаашид орчин нөхцлийг сайжруулах тал дээр анхаарч ажиллах.
- Үйлчлүүлэгчдийн бүртгэл мэдээллийг сайжруулах
- Нийт хүн амын дунд мэдлэг мэдээллийг сайжруулж ардаас нь явах бус үйлчилгээ авахаар өөрсдөө ирэхэд нь чиглэсэн арга хэмжээ авах
- ТББ-тай хамтран ажиллаж үйлчилгээг хүргэх тал дээр анхааран ажиллах, ялгаварлан гадуурхалтгүй, хувь хүний нууцийг хамгаалан ажиллах
- Серологийн лабораторийн эм оношлуурыг ахуйн зориулалттай хөргөгчинд хадгалж байгаад анхааран цаашид зориулалтын хөргөгчинд хадгалахыг санал болголоо.

СААД БЭРХШЭЭЛ:

- БЗДХ-ын эмч нарын цалин, урамшуулал муу тул хүний нөөц тогтворгүй байдаг.
- Үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөхөд шилэн хаалттай тул хувь хүний нууц алдагдах, иргэд зөвлөгөө авахаас цааргалах зэрэг талууд ажиглагддаг.
- Хүний нөөц дутмагаас үүдэн хавьтал судлалын хөөцөлдлөгөө муу байна.

СЕРОЛОГИЙН ЛАБОРАТОРИ

Уулзсан хүмүүс:

1. Б.Саранцэцэг, Серологийн ахлах лаборант
2. н.Баттөмөр, Серологийн лаборант

Лабораторийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Оношлуурууд монгол заавартай ирж байгааг ахуйн хэрэглээний хөргөгчинд хадгалж байна.



ЭМИЙН САН

Уулзсан хүмүүс:

1. Э.Цэдэндаш, Эмийн сангийн эрхлэгч

Эмийн зарцуулалтын тайланг байгууллагын нягтлан сар бүр гаргадаг. Кабинет бүр сар, долоо хоногоор гарган нягтланд мэдэгддэг. Эмийн санч 3 хоногийн сургалтанд хамрагдсан бөгөөд НҮБХАС-ын “CHANNEL” Хангамжийн Удирдлагын онлайн системд холбогдон эмийн ханган нийлүүлэлтийн мэдээ мэдээллээр харилцан хамтран ажиллаж, эмийн хугацаа дуусч устгагдах болон эм тасалдах гэх мэт аливаа эрсдэлээс сэргийлэн хамтран ажиллах бололцоотойг сануулж зөвлөгөө, дэмжлэгийг өглөө. Түүнчлэн оношлуурыг хөргөгчинд байрлуулахдаа хананд нь хэт тулгахгүй байх хэрэгтэй.



НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН СҮРЬЕЭГИЙН ДИСПАНСЕР

Уулзсан хүмүүс:

1. Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн тасгийн зохицуулагч эмч
О.Оюунтүлхүүр

Ерөнхий мэдээлэл

Төв аймаг сүрьеэгийн өвчлөл өндөр 8 аймагт ордог, СТСА-ны 2018 оны тайлангаар 10,000 хүн амд сүрьеэгийн тохиолдлын түвшин 9.7 байгаа нь улсын дундажаас (10,000 хүн амд 11.3) бага боловч аймгийн дундажаас (10 000 хүн амд 8.4) өндөр байна. Тус аймаг газар нутаг их, сүрьеэд өртөх эрсдэлт бүлгийн хүн ам болох явуулын хүн ам олон, улсын болон орон нутгийн чанартай уул уурхай ихтэй.

2019 онд нийт 31 хүн сүрьеэгээр оношлогдсон бөгөөд үүний 29 нь шинэ тохиолдол, 2 нь ЭТС-ийн тохиолдол бүргэгдсэн байна.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Цэрний сорьц авах кабиныг мөн төслөөр ханган нийлүүлснийг тасаг дотор байрлуулан ажиллуулж байгаа. Жене-эксперт, зөөврийн рентген аппарат, гэрлийн болон флюоресценц микроскоп хэт ягаан туяаны зөөврийн болон суурин гэрэл, шүүлтүүртэй амны хаалт, ширээний компьютер зэргийг төслий шугамаар ханган нийлүүлэлт хийсэн.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Сүрьеэгийн диспансери 18 ажилтантай: 5 их эмч, 1 эмийн мэргэжилтэн, ээлжийн 5 сувилагч, 5 асрагч, МСТН-ийн 1 ажилтан ажилладаг хүний нөөц хангалттай. Сүрьеэгийн тасаг 20 ортой үүний 3 нь ЭТС-ийн ор бөгөөд тухайн өдөр 26 өвчтөн хэвтэж байна. Сүрьеэгийн тасаг, амбулатори нэг байранд байдаг, эрүүл зүйн үзлэгийн кабинет нэгдсэн эмнэлгийн амбулаторид байрладаг, сүрьеэгийн лаборатори нь нэгдсэн эмнэлгийн харьяа ба 1 лаборант ажилладаг.

2010 онд ЭТС-ийн 3 ор бүхий тасаг байгуулж ГС-ийн дэмжлэгт төслөөр механик агааржуулалтын систем суурилуулсан, агааржуулалтын системийн шүүлтүүрийг

төслөөр авч хугацаанд нь сольдог боловч 2018 онд мотор шатаж засвар хийлгэсэн боловч одоо хэвийн үйл ажиллагааг хангахгүй, дуу ихтэй учир тогтмол ажиллуулахгүй байгаа. Уг байшин нь огт агааржуулалтын системгүй баригдсан учир тасаг, амбулаторийн бусад өрөөнд НЭ-ийн санхүүжилтээр агаарыг зөвхөн сорж гаргадаг агааржуулалтын систем нэмэлтээр суурилуулсан.



Эм барих мэргэжлийн бага эмч сүрьеэгийн эмийг хариуцдаг, сүрьеэгийн эм хадгалах өрөөг тасаг дотор байгуулсан, чийгшил, температур хэмжигч болон Пазер хадгалах зориулалтын хөргөгчтэй. Хугацаа дууссан болон дөхөж байгаа (3 сарын дотор) эм байхгүй. Тухайн өдрийн байдлаар эмчилгээтэй 55 өвчтөн байгаа, бүх өвчтөнд эмийг савласан.



2018 оны 11 сард хийсэн үзлэгээр 345 хүн хамруулсанаас 39 сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдсэний 6 эмэнд тэсвэртэй сүрьеэ илэрсэн.

Зөөврийн рентген аппаратын техникчээр 5 хүн сургасны 1 нь ажлын шаардлагаар чөлөөлөгдсөн.

Сүрьеэгийн лабораторид био аюулгүй шүүгээ, Жене-Эксперт аппарат, флюоресценц микроскопи зэрэг төхөөрөмж ханган нийлүүлэгдсэн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа боловч сорох шүүгээний хаалга хаагдахгүй гацсан хэвээр байна.



ТӨСЛИЙН ҮР ДҮН: МСЭМХ-ны хариуцан хэрэгжүүлж байгаа “Сүрьеэгийн сорьц тээвэрлэх” үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж 27 сум хамрагдан ажиллаж байна, 2018 оны 11 дүгээр сард тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бүх сумдын багийн дарга, багийн бага эмч нарыг сүрьеэгийн сургалтад хамруулан ажилласан

МСТН-ийн хариуцан хэрэгжүүлж байгаа сайн дурын идэвхтэн (СДИ)-ий үйл ажиллагаа явагдаж байна. Төслийн санхүүжилттэй холбоотой хоол эмчилгээний цэгийн үйл ажиллагаа зогсож СДИ-ий тоо цөөрсөн ба аймгийн хэмжээнд 7 СДИ ажиллаж өвчтөний эмийг гэрээр уулгах, асуулгын аргаар илрүүлэг хийх зэрэг ажлыг гүйцэтгэж байна.

Нэгдсэн эмнэлэг Зөөврийн дижитал рентгентэй болсоноор илрүүлэг үзлэгийг идэвхитэй зохион байгуулж байгаа. 2019 оны 2 сарын 18-аас 3 сарын 27-ны хооронд 16 суманд Сүрьеэгийн эрт илрүүлэг хийж 4400 зургыг зөөврийн рентген аппаратаар авсан.



Зөөврийн дижитал рентген аппаратын хадгалалт

ТАЙЛАН: TUBIS-ийг бүрэн ашиглаж мэдээллийг тогтмол оруулж байна, НЭ-ийн интернетийн хурдны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан гацах тохиолдол багагүй гардаг.

Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэг

Уулзсан хүмүүс:

Х.Мөнгөнцэцэг-зохицуулагч эмч

2018 онд нийт 2056 хүнээс ДОТС-ын асуумж судалгаа авсанаас 8 хүн сүрьеэгээр оношлогдсон. 2019 онд 208 хүнээс мөн авсанаас 2 тохиолдол илрүүлсэн. 2019 оны байдлар сүрьеэгийн 2 шинэ тохиолдлыг илрүүлсэн. Одоогийн байдлаар 9 өвчтөнд эм уулгаж байна.

СДИ 2018 онд 12 байсан, 2019 онд 7 ажиллаж байгаа. Сардаа 40 ам.долларын урамшуулал авдаг бөгөөд үүнд унааны болон бусад зардал багтсан байдаг. Цалин цагтаа өөрсдийн дансруу нь шилжин ордог.

1 өвчтөнд хүнс олгодог ба сард 35000 төгрөгийн үнэ бүхий хүнсийг хүнсний дэлгүүртэй гэрээ байгуулан олгодог. Үүнд: 10 кг гурил, 5 кг будаа, сүү, ургамалын тос багтана.

Хүсэлт:

- Хоолтой эмчилгээний хөтөлбөр 2017 онд дууссан ба тус хөтөлбөр нь маш үр дүнтэй байсан тул үргэлжлүүлэх;
- Бичиг хэргийн зардал 5000 төгрөг сардаа хүрэлцдэггүй тул нэмэгдүүлэх.

Дүгнэлт:

- Төв аймагт төслийн үйл ажиллагаа хангалттай хэрэгжиж байна;
- Ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, эм, урвалж бодисын хадгалалт, ашиглалт шаардлага хангасан;
- 2018 онд ХӨСҮТ-ээс хийсэн дэмжлэгт хяналтаар ЭМГ болон НЭ-т 6 зөвлөмж өгсөний 66.7% (4) бүрэн биелж, механик агааржуулалтын систем ажилд орсон

боловч мотор доголдолтой учир тогтмол ажиллахгүй, эмнэлгийн өргөтгөл барих асуудал хэлэлцэх шатандаа явж байна.

Зөвлөмж:

- Хурдавчилсан оношилгооны аппаратын (Жене-Эксперт) ашиглалтыг сайжруулах, лаборантын ажлын зохицуулалт хийх шаардлагаар НЭ-ийн эмч мэргэжилтнүүдэд хурдавчилсан шинжилгээний талаар тусгайлан сургалт хийх;
- Механик агааржуулалтын системийг тогтмол ажиллуулах талаар мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;
- Сүрьеэгийн тархвар судлаач эмч байхгүй тул цаашид авч ажиллуулах;
- Био Аппарат 2015 онд эвдэрч хаалга нь хаагдахгүй болж улмаар халдвар тарах эрсдэлд орсон байхад өдийг хүртэл засварлаж арга хэмжээ аваагүй байгааг нэн даруй засварлах хэрэгтэй;
- Ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн цаашдын ашиглалтанд анхаарч даатгалд хамруулах. Засвар үйлчилгээг сайжруулах;
- 20 өвчтөнд зориулсан өрөөнд 30 хүн байгаа тул өрөө байрны асуудалд анхаарах шаардлагатай;
- Халдварт, сүрьеэгийн барилга стандартын дагуу баригдаагүй;
- Аппарат, тоног төхөөрөмжийн ашиглалтын хуудсыг хэрэглэж хэвших.
- Хүний нөөцийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах.

ДУНДГОВЬ АЙМАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Уулзсан хүмүүс:

1. Г.Бат-Орших, ЭМГ-ын дарга
2. Л.Ганбат, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
3. П.Оюунчимэг, Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
4. Б.Саруулцэцэг, Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
5. Х.Жаргал, Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч



Ерөнхий мэдээлэл:

Дундговь аймаг нь 2017 оны эцсийн байдлаар 14556 өрхийн 46.4 мянган хүн амтай байгаа бөгөөд иргэдийн 34.1 хувь нь 17 хүртэлх насны хүүхдүүд, 35.6 хувь нь 18-39 насны залуучууд, 22.2 хувь нь 40-60 насныхан, 8.1 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байна. Дундговь аймаг нь Засаг захиргааны хувьд 15 сум, 66 багтай, 7469,0 мянган га нутаг дэвсгэртэй, газар нутгийн хэмжээгээр Монгол улсын нутаг дэвсгэрийн 4,5%-ийг эзэлдэг, аймгийн төв Улаанбаатар хотоос 265 км-т байрладаг, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймгуудтай хиллэдэг.

Эрүүл мэнд:

Сүрьеэгийн өвчлөлийн хувьд бага аймгуудын нэг боловч сүүлийн жилүүдэд өвчлөл нэмэгдэх хандлагатай байна. Өмнө нь ГС-ийн санхүүжилтээр хэрэгжиж байсан Сүрьеэгийн хоолтой эмчилгээг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Түүнчлэн хорих 429-р ангийн зөөврийн дижитал рентгенийг 2018 онд түр авч үзлэг шинжилгээг Засаг даргын 5,2 сая төгрөгийн санхүүжилтээр 5 газарт амжилттай зохион байгуулсан. Улмаар 5 шинэ сүрьеэгийн тохиолдол, 3 эмэнд тэсвэртэй сүрьеэг олж илрүүлэн эмчилсэн. Цаашид ч тус санхүүжилтийн хүсэлтийг дахин хүргүүлж зүүн, баруун сумдаар бүсчилсэн үзлэг, шинжилгээг өргөн бүрэлдэхүүнээр хийхээр төлөвлөж байна. Энэ ч утгаараа зөөврийн рентген аппаратын хэрэгцээ их байна. Түүнчлэн осол гэмтэл их ирдэг тул хүмүүсийг рентген аппаратаар шинжлэх хэрэгцээ ихээхэн гардаг.

Төсвийн 70 орчим сая төгрөгийн санхүүжилтээр 2018 онд Халдварт сүрьеэгийн тасагт агааржуулалтын системийг суурилуулсан.

МСЭМХ-аас сорьц тээвэрлэлтийн талаар бүх сумд, өрх багийн эмч, мэргэжилтнүүдийг сургасан.

Аймгийн хэмжээнд

1. 2018 “Эрүүл цус-1” аянд 7344 хүн хамруулан 146 тэмбүүгийн тохиолдол олсоны 45 нь шинэ тохиолдол байсан. Нийт өвчлөлийн 36% ажилгүй иргэд бөгөөд 56% нь эрчүүд байсан.
2. “Эрүүл цус-2” аяныг 2019 онд 5 сумаар ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

2018 онд эрүүл иргэнтэй Дундговь бодлогын баримт бичигт өвчлөлийн эрт илрүүлгийн талаар тусган оруулсан нь орон нутгаас санхүүжилт босгоход түлхэц болохуйц захирамж болжээ.

САНАЛ: Цаашид Аймгийн хэмжээнд зөөврийн рентген аппаратыг хуваарилж өгвөл үзлэг, шинжилгээг цаг алдалгүй хийгээд явах хүсэл эрмэлзлэлтэй байгаа тул энэ талын туслалцааг үзүүлэхийг хүсэж байлаа.

БЗДХ-ЫН КАБИНЕТ, СДЗШ-НИЙ ТӨВ

Уулзсан хүмүүс:

1. Ж.Уртнасан, Нэгдсэн Эмнэлгийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн эмч
2. М.Оюунгэрэл, БЗДХ-ын бага эмч, сувилагч эх баригч
3. Г.Содномдаржаа, ЭМГ-ийн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

ГС-ийн дэмжлэгээр 2017 онд аймгийн хэмжээнд 8000 хүнийг БЗДХ-ын үзлэг шинжилгээнд хамруулсан. Ажиллах хүч бага тул СДЗШ болон БЗДХ-ын кабинет нэг дор үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тэтгэвэрт гарсан эмчийг гэрээ байгуулан БЗДХ-ын эмч Арьс, харшлын эмчийн үүргийг давхар гүйцэтгүүлдэг. Кабинетийн өрөө тасалгааны хүрэлцээ сайн боловч цаашид тохижуулалт хийх шаардлагатай.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: ГС-ийн бэлгэвч, эм урвалжийн ханган нийлүүлэлтийг Эм-Импексээс хүлээн авсан. 2018 оны 1 сард ирсэн оношлуур 2019 оны 4 сард дууссан тул тендерээр нэмэлт оношлууруудыг Мон фармаас монгол заавартайгаар хүлээн авч ажиллаж байна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: ГС-ийн дэмжлэгээр 2017 онд аймгийн хэмжээнд 8000 хүнийг БЗДХ-ын үзлэг шинжилгээнд хамруулсан. Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн өвчлөл, сайдын тушаал зэргийг үндэслэн эмийн захиалгыг хийдэг. ХӨСҮТ-ээс дунджаар 3-6 сарын эмийн нөөцийг хүлээн авдаг. Аймгийн эмийн сангаасаа захиалгын хуудсыг бөглөн эмийг хүлээн авдаг. БЗДХ-ын резидентурт 1 хүн сураад 4 сарын сүүлээр ирнэ. 2016, 2018 онуудад 1,1 төрөлхийн тэмбүү бүртгэгдсэн. Эмэгтэйчүүд цус урвалжсаны дараа ирдэг бол эрчүүдэд өвчлөл шууд илэрдэг тул цочирдоод цаг алдалгүй ирдэг.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: 2019 оны 1-р улиралд 539 хүнийг үзлэг, оношлогоонл хамруулсанаас 15 тэмбүүгийн (эр 6, эм 9) шинэ тохиолдол бүртгэгдсэнээс 2 нь хавьтлаас илэрсэн. Түүнчлэн 12-заг хүйтэн, 17 трихомониаз илэрсэн. Хүний нөөц нэмэгдвэл хавьтал илрүүлэг нэмэгдэх боломжтой. Хавсарсан хэлбэрийн өвчлөл бүртгэгдээгүй байна.

ТАЙЛАН: Төслийн тайланг улирал бүр ХӨСҮТ-рүү илгээдэг.



ҮЗЭ-ийн ЗӨВЛӨМЖ:

- Зөвлөгөө, шинжилгээнд байнга хамрагдан ирдэг иргэдээс гадна яг өвчлөл гарч буй нас, бүлгийн хүмүүсийг чиглэсэн үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлэн, тэдгээр хүмүүсийг олж оношлох эдгээхэд зохих анхаарлыг хандуулан ажиллах
- Нийт хүн амын дунд мэдлэг мэдээллийг сайжруулж өөрсдөө ардаас нь явах бус үйлчилгээ авахаар ирэхэд нь чиглэсэн арга хэмжээ авах
- ТББ-тай хамтран ажиллаж үйлчилгээг хүргэх тал дээр анхааран ажиллах, ялгаварлан гадуурхалтгүй, хувь хүний нууцийг хамгаалан ажиллах
- Цаашид БЗДХ-ын нэг эмч нэмж ирэхэд намраас 2 дахь эмчийг сургаж ирүүлэхийг ХӨСҮТ-ээс зорин ажиллах болно.
- Хавьтал судлалыг сайжруулахгүйгээр БЗДХ-г тогтоон барих боломжгүйг анхааран ажиллах
- Өсвөр үе, залуус, эрсдэлт бүлгийн хүн амд зориулан СДЗШ-ний төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэн цаашид түргэвчилсэн тестийг авч хэрэглэх.
- НҮБХАС-ын “CHANNEL” Хангамжийн Удирдлагын онлайн системд холбогдон эмийн ханган нийлүүлэлтийн мэдээ мэдээллээр харилцан хамтран ажиллаж, эмийн хугацаа дуусч устгагдах болон эм тасалдах гэх мэт аливаа эрсдэлээс сэргийлэн хамтран ажиллах бололцоотойг сануулж зөвлөгөө, дэмжлэгийг өглөө.

СААД БЭРХШЭЭЛ:

- БЗДХ-ын эмч нарын цалин, урамшуулал муу тул хүний нөөц тогтворгүй.
- Орон тооны тархвар судлаач хэрэгтэй.
- Үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөхөд шилэн хаалттай тул хувь хүний хууц алдагдах иргэд зөвлөгөө авахаас цааргалах зэрэг талууд ажиглагддаг.
- Хүний нөөц дутмагаас үүдэн хавьтал судлалын хөөцөлдлөгөө муу байна.

СЕРОЛОГИЙН ЛАБОРАТОРИ

Уулзсан хүмүүс:

1. П.Нямрагчаа, Лабораторийн тасгийн эрхлэгч
2. Б.Уранцэцэг Серологийн эмч
3. Ц.Галсандэлгэр, Серологийн лаборант

Лабораторийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Оношлуурууд шаардлагын дагуу монгол заавартай ирж байна.

ЗӨВЛӨМЖ

- Лабораторид 1980-д оноос хойш хэрэглэхээ больсон Канийн урвалжийг Дундговь аймаг тавиад RW тамга дараад байна гэсэн мэдээлэл гараад байгаа тул тохирох дардас тэмдгийг ойрын хугацаанд хийлгүүлж ашиглах хэрэгтэй гэдгийг санууллаа.



ЭМИЙН САН



Ханган нийлүүлэгдсэн эмийн хадгалалт хамгаалалт сайн. Эм хангалттай ханган нийлүүлэгддэг, тасардаггүй. Кварцийн гэрэл хэвийн ашиглагдаж байна.

НҮБХАС-ын “CHANNEL” Хангамжийн Удирдлагын онлайн системд холбогдон эмийн ханган нийлүүлэлтийн мэдээ мэдээллээр харилцан хамтран ажиллаж, эмийн хугацаа дуусч устгагдах болон эм тасалдах гэх мэт аливаа эрсдэлээс сэргийлэн хамтран ажиллах бололцоотойг сануулж зөвлөгөө, дэмжлэгийг өглөө.

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН СҮРЬЕЭГИЙН ДИСПАНСЕР

Уулзсан хүмүүс:

1. П.Наранзул-Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн зохицуулагч эмч

Ерөнхий мэдээлэл

Дундговь аймаг сүрьеэгийн өвчлөл дунд түвшний аймгийн нэг бөгөөд 2018 оны статистик тайлангаар сүрьеэгийн тохиолдлын түвшин 10 000 хүн амд 7.0 байгаа нь сүрьеэгийн өвчлөл дунд аймгийн тоонд орж байна.

Сүрьеэгийн 2 их эмч, дүн бүртгэл, цахим систем, эм хариуцсан 1 сувилагч, халдвартын ээлжийн 5 сувилагч, 5 асрагч ажилладаг, 1 сүрьеэгийн лаборант нь ажлын ачаалалтай холбоотойгоор бактериологи шинжилгээг хавсран хийдэг, 1 их эмч ГС-ын дэмжлэгт төслөөр сүрьеэгийн эмчийн мэргэжил олгох курсэд сурч байна. Сүрьеэгийн тасаг 5 ортой, ЭТС-ийн тасаг тусгайлан байхгүй боловч 1 өрөөг ЭТС-тэй өвчтөн хэвтэхэд зориулан тохижуулсан. Тасаг амбулатори тусдаа байрладаг, амбулаторид эрүүл зүйн үзлэгийг өвчтөний үзлэгтэй хамт хийдэг, лаборатори НЭ-ийн лабораторитой хамт байрладаг.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Сүрьеэгийн тасгийн зохион байгуулалтад НЭ-ийн зүгээс онцгой анхааран дотоод зохион байгуулалт хийн өвчтөн хүлээн авах хэсгийг тусгайлан бий болгож ГС-ын төслөөр ханган нийлүүлсэн цэрний сорьц авах кабиныг хүлээн авах хэсэгт байрлуулан стандартын дагуу агаажуулалтын хоолойтой холбон ажиллуулж байна. Хэт ягаан туяаны зөөврийн болон суурин гэрэл, шүүлтүүртэй амны хаалт, ширээний компьютер зэргийг төслийн шугамаар ханган нийлүүлэлт хийсэн.TUBIS-ийг бүрэн ашиглаж мэдээллийг тогтмол оруулж байна. ЭМЯ-ны хөрөнгө оруулалт 70.0 сая төгрөгийн санхүүжилтээр сүрьеэгийн тасагт механик агааржуулалтын системийг суурилуулж үйл ажиллагаанд оруулсан нь тун сайшаалтай байна. Агааржуулалтын систем нь тасгаар хязгаарлагдахгүй 1 дүгээр давхарт байрладаг амбулаторийн өрөөтэй холбогдсон нь орчны халдвар хяналтын чухал арга хэмжээ болжээ.



Сүрьеэгийн эм хадгалах өрөө тасаг дотор байдаг, чийгшил, температур хэмжигчтэй тогтмол хөтөлдөг ба энэ өрөөнд зөвхөн өвчтөнд савласан эмийг хадгалдаг, агуулахын эмийг НЭ-ийн эмийн агуулахад хадгалдаг. Хугацаа дууссан болон дөхөж байгаа (3 сарын дотор) эм байхгүй.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Сүрьеэгийн лабораторид ГС-ийн дэмжлэгт төслөөр урвалж бодис, микроскопи, компьютер зэрэг төхөөрөмж ханган нийлүүлэгдсэн, үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа боловч өрөө тасалгааны хувьд лабораторийн шаардлага хангахгүй, 2019 онд нэгдсэн эмнэлгийн шинэ байр баригдах төлөвлөгөөтэй байгаа тэнд бүх лабораторийг оруулах төлөвлөгөөтэй гэж НЭ-ийн удирдлага танилцуулав.



ТӨСЛИЙН ҮР ДҮН: МСЭМХ-ны хариуцан хэрэгжүүлж байгаа “Сүрьеэгийн сорьц тээвэрлэх” үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж 15 сум хамрагдан ажиллаж байна, 2018 онд төслийн үйл ажиллагааны хүрээнд бүх сумдын багийн дарга, багийн бага эмч нарыг сүрьеэгийн сургалтад хамруулан ажилласан. Бүх сумдыг цэрний сорьц тээвэрлэх зориулалтын сав, сорьц хадгалах хөргөгчөөр хангасан.

МСТН-ийн хоол эмчилгээний цэгийн үйл ажиллагаа зогссон боловч орон нутгийн санхүүжилтээр сүрьеэгийн тасагт хэвтэж буй өвчтөнүүдэд нэмэлт хоол өгдөг, ЭТС-тэй өвчтөнд гаж нөлөөний эмээр хангах, Пазер ууж буй өвчтөнд сүү тараг өгөх зэргээр дэмжлэг үзүүлж байна. Тус аймагт сумдаас сорьц тээвэрлэгч нарыг сонгохдоо сургагдсан СДИ-ийг сонгон ажиллуулсан нь давуу талтай байна.

ТАЙЛАН: Тайланг 2012 оноос TUBIS програмд шивж оруулдаг.

Дүгнэлт:

- Дундговь аймагт төслийн үйл ажиллагаа хангалттай хэрэгжиж байна;
- Ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн хадгалалт, ашиглалт шаардлага хангасан;
- 2018 онд ХӨСҮТ-ээс хийсэн дэмжлэгт хяналтаар ЭМГ болон НЭ-т 6 зөвлөмж өгсөний 83.3% (5) бүрэн биелж, лабораторийн урсгал дотоод зохион байгуулалттай холбоотой зөвлөмжийг байрны асуудлаас болж бүрэн шийдвэрлээгүй байна;
- Зөөврийн рентген аппарат шаардлагатай.

Зөвлөмж:

- Шинээр баригдах байшингийн зураг гаргахдаа лабораторийн агаарын урсгалыг тооцоолж өрөө тасалгааг зөв байрлуулах зэргээр мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах;
- Лаборант тэтгэвэрийн нас дөхөж байгаа учир сүрьеэгийн лаборант бэлдэх;
- Сүрьеэгийн тасаг, диспансерийн механик агааржуулалтын системийн гэмтлийг шийдвэрлэх шаардлагатай;
- Сүрьеэгийн тархвар судлаач эмч байхгүй тул цаашид авч ажиллуулах;
- Аппарат, тоног төхөөрөмжийн ашиглалтын хуудсыг хэрэглэж хэвших;
-

МОНГОЛЫН ӨРХИЙН АНАГААХ УХААНЫ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХОЛБОО /МӨАУМХОЛБОО/

Уулзсан хүмүүс:

1. Т.Урангоо-их эмч
2. н.Оюунчимэг-сувилагч

Тус аймгийн “Өлзийт мандал” өрхийн ЭМТөв нь аймгийн төвийн 7,8,9 дүгээр багийн 5600 орчим хүнд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг. МӨАУМХ-ны зохион байгуулсан сургалтад эмч, мэргэжилтэн хамрагдсан. Тухайн өдрийн байдлаар хяналтанд эмчилгээтэй өвчтөн байхгүй, сүрьеэгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой маягтаар хангагдсан, хөтлөгддөг.

Цалин цагтаа шилжин ордог, эм уух буланг тохижуулсан. Гарын авлага дутагдалтай байдаг.



ӨМНӨГОВЬ АЙМАГ

Өмнөговь аймгийн ЭМГ-ын удирдлага

Уулзсан хүмүүс:

1. Ц.Өнөржаргал, ЭМГ-ын дарга
2. Ж.Отгонбайгал, ЭМГ, ЭТҮХ-ийн дарга
3. М.Булганчимэг, ЭМГ, НЭМТ-ийн дарга
4. Л.Болдбаатар, БОЭТ-ийн дарга
5. Түвшинзул, Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
6. Б.Бямбажав, ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
7. Цэцэгжаргал, Тархвар судлаач
8. Буянжаргал, Хүний нөөцийн менежер
9. Отгонбаяр, Сүрьеэгийн эмч
10. Уртнасан, БЗДХ-ын эмч
11. Б.Буджав, “Говийн Ухаан” ТББ-ын гүйцэтгэх захирал

Ерөнхий байдал:

Өмнөговь аймаг нь 165,0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 15 сум, 59 багтай. Аймгийн төв Даланзадгад хот. Өмнөговь аймаг нь Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баянхонгор, баруун хойд хэсгээр Өвөрхангай, хойд талаараа Дундговь, зүүн талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино. Аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай. Монгол улсын хэмжээнд хамгийн том 165,0 мянган кв.км нутаг дэвсгэртэй ба хүн амын суурьшил сийрэг 3,4 квадрат километр нутагт 1 хүн, 13,2 квадрат километр нутагт 1 өрх ноогдон хүн ам суурьшиж байна. Өмнөговь аймаг нь 2018 оны жилийн эцэст 68114 хүн амтай болж 2017 оны жилийн эцсийн хүн амын мэдээнээс 3,7 хувиар буюу 2469 хүнээр өслөө. Нийт хүн амын 50,3 хувь эрэгтэйчүүд, 49,7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хөдөлмөр эрхлэх насаар нь ангилвал 32,7 хувийг 0-15 насны хүүхэд, 61,4 хувийг 16-59 насны, 5,9 хувийг 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Өрхийн тоо 21983 болж өмнөх оноос 609 өрхөөр буюу 3,3 хувиар өссөн дүнтэй байна.

Эрүүл мэнд

Аймгийн хэмжээгээр эрүүл мэндийн байгууллага 94 ажиллаж байгаагаас улсын төсвийн эмнэлэг 17, өрхийн эмнэлэг 4, цэргийн ангийн 3 эмнэлэг, хувийн эмнэлэг 25, хувийн эмийн сан 27, эргэлтийн эмийн сан 14, эм ханган нийлүүлэх төв 4 тус тус ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарт 189 их эмч, 362 дунд мэргэжилтэн ажиллаж байна. 2018 оны эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээгээр 1536 эх амаржиж, 323 хүн нас барсан нь урьд оны мөн үеэс төрөлт 18,4 хувиар, нас баралт 34,9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд оны эхний 12 сарын байдлаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл 23 гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 10,0 хувиар, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2 гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 60,0 хувиар тус тус буурсан байна.



Уул уурхай хөгжиж байгаатай холбоотойгоор 10,000 орчим жолооч болон өөр аймгуудын иргэд ирж ажилладаг. Түүнийг дагасан осол гэмтэл, өвчлөл ихээр гардаг нь эмнэлгийн санхүүжилтэнд нөлөөлдөг. Түүнчлэн энэ талаар бусад орнуудын туршлагыг судлан тэдгээр иргэдийг аливаа өвчнөөс урдчилан сэргийлэх

болон бэлгэвчийг хувийн хэрэгцээндээ худалдан авах дадлыг хэвшүүлэх санаачлагыг гарган зүүн болон баруун замуудаар ажиллах хэрэгтэй байна.

Өнгөрсөн хугацаанд орон нутаг болон уул уурхайн үйлдвэрүүдийн санхүүжилтээр эрүүл мэндийн шат дараалласан үзлэг оношлогоо болон зарим хэрэгцээт тоног төхөөрөмжүүдийг худалдан авч ажилласан. Цаашид энэ төрлийн санхүүжилт буурах хандлагатай байна.

“Говийн ухаан” ТББ нь Төгс бүсгүйчүүд ТББ-ын дэд салбар хүлээн авагчаар 2017 оныг хүртэл ГС-ын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байсан. БЗДХ-ын түвшинг бага байлгах зорилгоор төслийн хугацаанд “Говийн Оюу” сантай хамтран өсвөр насны хүүхэд залуусд мэдээлэл өгөх, үйлчлүүлсэн иргэдийг “Ногоон картжуулах” ажлыг зохион байгуулж ажилласан. Түүнчлэн БЗДХ-аас сэргийлэх тараах материал, бэлгэвчээр ханган ажиллаж байсан. Төслийн санхүүжилт зогсоход байгууллагынхаа санхүүжилтын боломж бололцоон дээр тулгуурлан үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж үйлчлүүлэгчиддээ зөвлөгөө өгөн ажилласаар байна. Энэхүү ажлыг эхлүүлэх суурийг ЭМГ-ын дарга тавин хамтран ажилласан. Түүнчлэн БОЭТ-ийн тэтгэвэрт гарсан эмчийг авч ажиллуулж байсан нь нэг талдаа оносон боловч нөгөө талаар үйлчлүүлэгчид айж, санаа зовох зэрэг байдал ажиглагдаж байсан. Тиймээс цаашид эмчийн мэргэжлийн бус хүнийг зөвлөгөө өгөх, шинжилгээ авахад сурган орчинд нь ажиллуулбал илүү үр дүнд хүрэх боломжтой санагдаж байсан.

Зөвлөмж:

- 2015 оны эрүүл мэндийн сайдын 305-р тушаалд үндэслэн хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай. Тус тушаалд БЗДХ-ын кабинетэд хамгийн багадаа 15 хүн ажиллах ёстойгоос одоогоор эмч, сувилагч, серологийн лаборант л ажиллаж байна.
- СДЗШ-ны үйл ажиллагаа огт хэрэгжихгүй байна. Энэ БЗДХ-ын кабинетээс тусдаа үйл ажиллагаа явуулах учиртай. Хурдавчилсан оношлуурыг авч ажиллах
- Цаашид уурхайн эмч нарын мэдлэг, мэдээллийг тэлэх богино хугацааны сургалтуудад хамруулан сайтар хамтран ажиллах хэрэгтэй.
- 1980-1990 онуудад хийгдэж байсан “Нэр хаяггүй үйлчилгээ” өвчлөлийг тогтоон барьж ажиллахад сайн нөлөөтэй байсан. Ер нь бол ХДХВ-аас бусад бүхий л БЗДХ 1 удаагийн тариагаар эмчлэгддэг тул өвчтэй хүмүүсийн нууцыг ханган элдэв мэдээлэл шаардалгүй тариаг нь хийгээд явбал илүү үр дүнд хүрэх бололцоо бий.

Санал

- 2020 он хүртэл орон тоог нэмэх боломжгүй гэдэг мэдээлэл ирсэн төдийгүй цалингийн төсөв хэтрүүлбэл өөрсдөө төлөхийг сануулсан. ЭМГ-ийн БОЭТ, Дорнод аймгийн БОЭТ-тэй харьцуулахад 2 дахин бага буюу 242 ажилтантай Нэгдсэн Эмнэлгийн хүчин чадлаар ажиллаж байгаа атлаа хамаагүй их ачаалалтай байна. Архангай болон Ховд аймгуудын БОЭТ ч 400 гаруй ажилтантай байдаг. Тиймээс Хүний нөөцийн талаар цаашид албан бичгийг төлөвлөн ЭМЯ-д хүргүүлэх болно.

- Дүрс оношлогооны 3 эмч мэргэжилтэн ажиллаж байгаад 1 эмч гарсан тул цаашид эмчийн орон тоог нөхөж ажилтан авна.
- Уул уурхай их хөгжсөн тул сумдаар явж үзлэг, оношлогоог зохион байгуулах шаардлага тулгардаг. Тиймээс зөөврийн рентген аппарат зайлшгүй шаардлагатай байгааг харгалзан үзэж дараа дараагийн санхүүжилтээр шийдэж өгөхийг хүсэж байна.
- ӨМГ өвөрмөц онцлогтой аливаа төрлийн эрсдэл ихээр тулгардаг тул стандартад хүрч ажиллахыг эрмэлзэн ажиллаж байгаа, цаашид урдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийг үр дүнтэй зохицуулахад анхаарч ажиллахыг эрмэлзэнэ.
- Улсын хэмжээний хүн амын шилжилт хөдөлгөөн нилээд замбараа муутай. Зарим иргэд шилжин очсон газраа бүртгүүлэлгүй явж байдаг нь ЭМ-ийн байгууллагын тэнцвэртэй байдалд нөлөөлж байна. Жишээлбэл: 2018 онд Дарханы иргэн Оюу Толгой ХХК-д Өмнөговь аймгийн харъяанд бүртгүүлэн ажиллаж байгаад Дарханд очиж эндсэн хэрэг гарсан бөгөөд тус иргэн энд байх хугацаандаа нэг ч удаа ЭМ-ийн үзлэг оношлогоонд орж байгаагүй. Үүнтэй холбогдон асуудалд орсон эмч ажлаа орхиж байна.
- Мөн бүртгэлгүй байж байгаад хийсвэр хагалгаагаар төрөх эх шууд ирээд л төрдөг нь эмнэлгийн санхүүжилтэд нөлөөлдөг. Тиймээс цаашид аливаа хүн орон нутгийн харъяаллаа солибол цахим хэлбэрээр шилжин очсон газар нь бүртгэгддэг болох шаардлагатай байна.
- Уул уурхайтай холбоотой гэр бүл салалт, өрх толгойлсон хүүхдүүд хаягдах, эндэх тохиолдлууд ихээр гарч байна.

БЗДХ-ЫН КАБИНЕТ, СДЗШ-НИЙ ТӨВ


Уулзсан хүмүүс:

1. Л.Нарантуяа, БЗДХ-ын кабинетын эмч
2. Л.Жавзандолгор, сувилагч

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Бэлгэвч, тараах материал, оношлуурын 30% болон БЗДХ-ын эмийг ханган нийлүүлдэг. Бэлгэвчний хэрэгцээ их байдаг боловч хангалт муу ирдэг.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: БЗДХ-ын 1 эмчийг ГС-ийн санхүүжилтээр сургаж байгаа бөгөөд 2019 оны 4 сард төгсөн ирж ажлаа хүлээн авна. Одоогоор тэтгэвэрт гарсан эмчтэй 6 сарын гэрээ байгуулан түр хугацаанд ажиллаж байна. 2018 онд 1 төрөлхийн тэмбүү гарсан. Учир нь жирэмсний эхний үедээ оношлогдоод тариа хийлгэсэн байсан ч дахин хавьталд орсоны дараа төрсөн байна. 2019 оны эхний улирлын байдлаар 28 тэмбүү илэрсэний 2 нь хавьтлаар илэрсэн байна. Өдөрт 25 хүнээс мазокын шинжилгээ авдаг.



Намар, хавар зохион байгуулагддаг цэргийн үзлэгээр 18-28 насны өвчлөл ихээр илэрдэг 600 орчим хүнийг үзлэг, оношлогоонд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэг рүүгээ чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.

САНАЛ:

- Хүний нөөцийг нэмэгдүүлэх эмч, сувилагч 2 тэтгэвэрт гарах насанд хүрсэн бөгөөд цаашид төгсөж ирэх 1 эмч зөвхөн амбулаторитоо ажиллах боломжтой бөгөөд дахин 1 эмч авч ажиллуулбал урдчилан сэргийлэх үзлэг болон орон нутагт өвчлөл, хавьтлын илрүүлэг хийж ажиллах бололцоо бүрдэнэ.

СЕРОЛОГИЙН ЛАБОРАТОРИ

Уулзсан хүмүүс:

1. Г.Жаргалмаа, Серологийн лаборант

Лабораторийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Оношлуурууд шаардлагын дагуу монгол заавартай ирж байна. Оношлуурыг орлого, зарлагын журналд бүртгэдэг. Өдөрт 50-иас дээш цус хүлээн авч ажилладаг.



ЭМИЙН САН

Уулзсан хүмүүс:

1. Б.Одонтуяа, Эмийн санч



Ханган нийлүүлэгдсэн эмийн хадгалалт хамгаалалт, орлого зарлагын бүртгэл үлгэр жишээ сайн. Хүлээн авсан газар тус бүрээр эм урвалж, бэлгэвчийн орлого, зарлагыг хийж ажиллаж байна. Эм хангалттай ханган нийлүүлэгддэг, тасардаггүй. НҮБХАС-ын “CHANNEL” Хангамжийн Удирдлагын онлайн системд холбогдон эмийн ханган нийлүүлэлтийн мэдээ мэдээллээр харилцан хамтран ажиллаж, эмийн хугацаа дуусч устгагдах болон эм тасалдах гэх мэт аливаа эрсдэлээс сэргийлэн хамтран ажиллах бололцоотойг сануулж зөвлөгөө, дэмжлэгийг өглөө.



СҮРЬЕЭГИЙН ДИСПАНСЕР

Уулзсан хүмүүс:

1. Ц.Отгонбаяр-Зохицуулагч эмч
2. Ш.Мишигдорж-Лаборант
3. Болормаа-дүн бүртгэгч, сувилагч

Ерөнхий мэдээлэл

2018 оны тайлангаар 10 000 хүн амд сүрьеэгийн тохиолдлын түвшин 3.2 байгаа нь сүрьеэгийн өвчлөл бага мэт боловч улсын чанартай том уурхайнуудтай холбоотой сүрьеэд өртөх өндөр эрсдэл бүхий хөдөлгөөнт хүн ам ихтэй. Хүн амын 40% нь түр оршин суугч буюу хөдөлгөөнт хүн ам. Сүүлийн жилүүдэд ЭТС-ийн тохиолдол тогтмол нэмэгдэж байгаа бөгөөд эдгээрийн 90% гаруй нь өөр аймаг, Улаанбаатарын харьяат хүмүүс байна.

Сүрьеэгийн 1 их эмч, 1 сувилагч амбулаторид ажилладаг, тасагт халдвартын ээлжийн сувилагч нар үйлчилгээ үзүүлдэг. Лаборант ажлын ачааллаас шалтгаалан клиникийн шинжилгээг давхар хийдэг. Сүрьеэгийн тасаг, амбулатори, лаборатори нь халдвартын тасгийн байранд байрладаг. Сүрьеэгийн тасаг 3 ортой, ЭТС-тэй өвчтөн хэвтэж эмчлүүлэн нэг өрөө гаргасан. Амбулаторит эрүүл зүйн болон өвчтөний үзлэгийг хамт хийдэг.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Эмийн агуулахын хадгалалт хамгаалалт сайн боловч сүрьеэгийн эмийг хувцасны шүүгээнд хадгалсан байна. Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 2 эм үлдсэн байна. 2019 оны 6 сар хүртэл ашиглахааргүй бол ХӨСҮТ-д өгч тооцоо нийлэх хэрэгтэй.



БОЭТ-ийн зүгээс сүрьеэгийн тасаг, амбулатори, лабораторийн зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэн халдвартын тасгийн 2 давхарт нэмэлт 5 өрөө гарган өгсөний 2 өрөөг тохижуулан сүрьеэгийн лаборатори орсон, ДЭМБ-ын санхүүжилтээр 2018 онд тус лабораторид Жене-Эксперт аппарат суурилуулан шинжилгээ хийж байгаа боловч цэрний сорьц авах кабин аваад 4-5 жил болж байхад суурилуулаагүй байна.

Өрөө тасалгаа хангалттай болж буй боловч тасаг, амбулатори, лаборатори байрлаж буй байшин нь байгалийн агааржуулалтын систем ч үгүй, зөвхөн цонх онгойлгож өрөөний агаарын солилцоог хийдэг нь сүрьеэгийн халдвар дотоод халдвар байдлаар тархах, улмаар эмнэлгийн ажилчид өвчлөх эрсдлийг бий болгож байна.



МСЭМХ-ны хариуцан хэрэгжүүлж байгаа “Сүрьеэгийн сорьц тээвэрлэх” үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж бүх сум хамрагдан ажиллаж байна, 2018 онд төслийн үйл ажиллагааны хүрээнд бүх сумдын эмч нарыг сүрьеэгийн сургалтад хамруулан ажилласан. Бүх сумдыг цэрний сорьц тээвэрлэх зориулалтын саваар хангасан.

МСТН-ийн СДИ-ий болон хоол эмчилгээний цэгийн үйл ажиллагаа зогссон.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: ГС-ийн дэмжлэгт төслөөр сүрьеэгийн эм, түрхэцийн шинжилгээний болон Жене-Экспертийн урвалж бодис, орчны хамгаалах хэрэгсэл болон суурин ба зөөврийн хэт ягаан туяаны гэрэл, хувийн хамгаалах хэрэгслийг хангадаг, сүүлийн жилүүдэд БОЭТ-с хувийн хамгаалах хэрэгсэл, тасагт хэвтэж буй сүрьеэтэй өвчтөний хордлого тайлах гэх мэт гаж нөлөөний эмээр хангаж байгаа.



ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа TUBIS програмд хийгддэг.

Дүгнэлт:

- Өмнөговь аймагт төслийн үйл ажиллагаа хангалттай хэрэгжиж байна;
- Ханган нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн хадгалалт, ашиглалт шаардлага хангасан;
- 2018 онд ХӨСҮТ-ээс хийсэн дэмжлэгт хяналтаар ЭМГ болон БОЭТ-д 9 заалт бүхий зөвлөмж өгсөний 55.6% (5) бүрэн биелж, хүний нөөцийг нэмэгдүүлэх буюу сүрьеэгийн эмч бэлдэх, цэрний сорьц авах кабиныг байрлуулах ашиглах, сүрьеэгийн тасаг, амбулаторийн орчны хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар халдвар судлагч эмчийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх ажил огт хэрэгжээгүй.

Зөвлөмж:

- Халдвартын тасгийн 2 давхарт ашиглах өрөөний урсгалыг зөв зохион байгуулах, цэрний кабиныг суурилуулж ажиллагаанд оруулах;
- БОЭТ-ийн шинээр баригдсан байшинд эрүүл зүйн үзлэг хийх өрөө гаргаж сүрьеэгийн эмчийг хуваариар ажиллуулах;
- Сүрьеэгийн эмч нэмж сургах.

**МОНГОЛЫН ӨРХИЙН АНАГААХ УХААНЫ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН
ХОЛБОО /МӨАУМХолбоо/**

Уулзсан хүмүүс:

1. Н.Лхагвасүрэн-Шинэ билэг ӨЭМТ-ийн захирал

Тус аймгийн “Шинэ билэг” ӨЭМТ-нь харьяаллын 9900 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлдэг, одоогоор хяналттай эмчилгээ хийлгэж байгаа хүн байхгүй боловч эм уулгах, нөхцөл хангалттай бүрдсэн.

МӨАУМХ болон СЭМХ-нөөс зохион байгуулагддаг сургалтанд байнга хамрагддаг. Өнгөрсөн онд шинэ байранд орсон, эмийн буланг тохижуулаагүй. Төслийн хүрээнд цэрний сав, сорьцны хөргөгч, сорьцны сав зэргийг хүлээн авсан.



Тайлан бичсэн:

ҮЗЗ-ийн ажлын өлбө

Хянасан:

Хяналтын бүлэг